210102	Нэмэгдэл	214,817,007.56	223,234,900.00	219,199,007.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,016,000.00	5,307,000.00	4,938,104.00
210104	Урамшуулал	71,864,113.00	75,526,700.00	73,423,693.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,902,258.75	165,955,700.00	165,759,483.12
210201	Тэтгэврийн даатгал	105,677,205.95	117,044,200.00	117,061,223.12
210202	Тэтгэмжийн даатгал	11,213,100.70	12,227,800.00	12,176,699.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,970,660.56	9,782,300.00	9,740,734.00

Нөмрөг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,248,364.14	2,445,600.00	2,412,140.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,792,927.40	24,455,800.00	24,368,687.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>293,959,800.19</b>	<b>314,540,800.00</b>	<b>310,456,824.59</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,049,392.19	15,126,000.00	12,706,530.59
210302	Түлш, халаалт	279,075,608.00	296,198,100.00	296,411,094.00
210303	Цэвэр, бохир ус	1,834,800.00	3,216,700.00	1,339,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,491,279.00</b>	<b>54,962,000.00</b>	<b>54,680,744.40</b>
210401	Бичиг хэрэг	7,986,100.00	7,573,300.00	7,573,300.00
210402	Тээвэр, шатахуун	27,494,960.00	32,616,600.00	32,384,290.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,669,119.00	6,776,800.00	6,776,454.00
210404	Ном, хэвлэл	157,500.00	210,600.00	162,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404,600.00	595,100.00	595,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,779,000.00	7,189,600.00	7,189,600.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>48,556,409.90</b>	<b>75,272,300.00</b>	<b>58,904,879.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,300,753.90	18,091,900.00	18,091,900.00
210502	Хоол, хүнс	32,213,956.00	52,808,200.00	36,440,879.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,041,700.00	4,372,200.00	4,372,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,072,700.00</b>	<b>4,399,400.00</b>	<b>4,399,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	78,000.00	755,200.00	755,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	317,500.00	317,500.00
210604	Урсгал засвар	3,994,700.00	3,326,700.00	3,326,700.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>4,625,000.00</b>	<b>8,262,000.00</b>	<b>7,842,100.00</b>
210702	Дотоод албан томилот	4,625,000.00	8,262,000.00	7,842,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,748,618.23</b>	<b>11,406,200.00</b>	<b>11,259,092.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,663,300.00	7,701,200.00	7,701,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	607,608.23	1,879,200.00	1,796,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	523,450.00	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,700.00	295,700.00	295,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	88,600.00	88,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,385,400.00	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	184,660.00	188,300.00	124,192.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,700.00	60,700.00	60,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		450,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,865,890.23</b>	<b>55,649,500.00</b>	<b>55,354,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,718,990.23	38,801,800.00	38,506,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,146,900.00	16,847,700.00	16,847,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,201,820.00</b>	<b>16,479,800.00</b>	<b>16,284,520.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,201,820.00</b>	<b>16,479,800.00</b>	<b>16,284,520.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,701,820.00	15,409,800.00	15,214,520.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,070,000.00	1,070,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>149,176,960.00</b>	<b>50,176,700.00</b>	<b>39,856,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>149,176,960.00</b>	<b>50,176,700.00</b>	<b>39,856,600.00</b>
223001	Бусад хөрөнгө	149,176,960.00	50,176,700.00	39,856,600.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>89,820,000.00</b>	<b>75,000,000.00</b>	<b>69,200,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	89,820,000.00	75,000,000.00	69,200,000.00

Нөмрөг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	919,700,772.19	2,058,088,400.00	2,035,203,609.46
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	1,200,984,400.00	1,169,190,533.30
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		1,200,984,400.00	1,169,190,533.30
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	833,499,023.19	723,032,300.00	756,882,256.16
122005	Орон нутгийн төсвөөс	789,420,580.19	672,855,600.00	706,705,559.16
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	44,078,443.00	50,176,700.00	50,176,697.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	17,192,930.00	18,949,400.00	18,654,200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,192,930.00	18,949,400.00	18,654,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	69,008,819.00	115,122,300.00	90,476,620.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,008,819.00	70,048,400.00	90,476,620.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		45,073,900.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>25,832,841.90</b>	-	8,423,143.90
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>8,423,143.90</b>	-	40,023,160.90
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	29.00	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	6.00	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	105.00	105.00	105.00
620001	Удирдах ажилтан	13.00	13.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	62.00	62.00	62.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	30.00	30.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	443.00	443.00	443.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	349.00	349.00	349.00
630001	Төрийн өмчит ЕБС	349.00	349.00	349.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	94.00	94.00	94.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	94.00	94.00	94.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>105.00</b>	<b>105.00</b>	<b>105.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00	9.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	60.00	60.00	60.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.00	5.00	5.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16.00	16.00	16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	8.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>198,849,006.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>173,549,006.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	117,652,982.45
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	18,009,949.00
210101	Үндсэн цалин		18,009,949.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	7,998,900.00
210303	Цэвэр, бохир ус		7,998,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	1,808,765.45
210401	Бичиг хэрэг		208,765.45
210402	Тээвэр, шатахуун	-	1,600,000.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	0.00	47,354,171.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	38,030,572.00
210502	Хоол, хүнс	-	9,323,599.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	2,949,397.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,949,397.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	39,531,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,182,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		349,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	53,861,324.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	53,861,324.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		27,261,324.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,600,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>2,034,700.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		2,034,700.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>25,300,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	25,300,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		25,300,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	198,849,006.45
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	198,849,006.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	52,204,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		146,644,209.45
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		460,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		460,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нөмрөг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нөмрөг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх, сум орон нутгаа хөгжүүлэх" зорилго, зорилт, чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сум нь дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нөмрөг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 2,986.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 84.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 33.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 130.4 сая төгрөг болж өмнөх оноос 38.5 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 24.7 сая төгрөг нь СХС-ийн, 15.3 сая төгрөг нь ОНХС-ийн, 90.4 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

#### Авлага

Авлага дансны үлдэгдэл 179.6 сая төгрөг болж өмнөх оноос 14.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь СХС-ийн авлага 19.7 сая төгрөгөөр буурсан, ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд үүссэн авлагатай холбоотой байна.

*/төгрөгөөр/*

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЗДТГ	94,063.00	-
ИТХ	226,000.00	226,000.00
ЭМТ	381,024.90	35,023,524.90
Соёлын төв	71,227.59	71,227.59
СХС	163,986,742.00	144,271,005.00
<b>ДҮН</b>	<b>164,759,057.49</b>	<b>179,591,757.49</b>

*Илрүүлэлт: ТШЗ-ын санхүүгийн аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 20.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.*

#### Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 154.2 сая төгрөг болж өмнөх оноос 17.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь эрүүл мэндийн төвд ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэн, хангамжийн материал 10.6 сая төгрөгөөр, түүхий эд материал 7.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,906.1 сая төгрөг болж 4.1 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ зэрэг байгууллагууд 38.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 129.0 сая

төгрөгийн хөрөнгө хандиваар, 11.6 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн болон 61.3 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн, элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөг дансны үлдэгдэл 19.6 сая төгрөг болж, өмнөх оноос 8.0 сая төгрөгөөр өссөн байна.

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ИТХ		552,453.46
ЭМТ	1,825,200.00	5,198,607.00
ОНХС	9,804,640.00	13,844,400.00
<b>ДҮН</b>	<b>11,629,840.00</b>	<b>19,595,460.46</b>

/төгрөгөөр/

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 3,350.7 сая төгрөг болж 67.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,025.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж, 21.6 сая төгрөгөөр бууруулж 2,003.6 сая төгрөгөөр баталсан байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,003.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,932.9 сая төгрөгийг урсгал зардалд, 50.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 75.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,201.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 672.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18.9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 50.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 70.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 45.1 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,169.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 706.7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 50.2 сая төгрөг, нийт 2,035.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 22.9 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 90.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 15.5 сая төгрөгөөр нэмж төлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,003.6 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 0.3 сая төгрөгийг сумын төсөвт, 28.1 сая төгрөгийг улсын төсөвт, 10.4 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 8.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 43.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 146.6 сая төгрөг, нийт 198.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 173.5 сая зарцуулж, үлдэгдэл 2.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг түвшнээс бага тул зөрчилгүй санал, дүгнэлт өгсөн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 21 мэдээллийн хугацаа хоцроосон байна. Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх хэсэгт 29.2 сая төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээг мэдээлэхээс 24.5 сая төгрөгийн зарлагыг мэдээлж, 4.7 сая төгрөгийн зарлагыг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нөмрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгч, бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 12.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 0.6 сая төгрөгийн алдааг залруулж, 7.5 сая төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 4.7 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 4.2.1 Залруулсан алдаа

Төвийн шууд захирагчийн тайланг нэгтгэхдээ Эрүүл мэндийн төвийн аудитлагдсан тайланг 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг залруулсан.

### 4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй

### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хяналттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтгүй гүйлгээ гаргасан, албан томилолтоор ажилласан албан хаагчдын хоол, буудлын төлбөр төлсөн, ЗГ-ын 43 дугаар тогтоолыг зөрчиж, техникийн комиссын шийдвэргүйгээр засвар сэлбэг худалдан авсан зэрэг 6.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.7 "энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд", 8 дугаар зүйлийн 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

**2. Хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ТШЗ-д олгосон санхүүжилтийг батлагдсан төсөвтэй тулгахад сумын Соёлын төвд батлагдсан төсвөөс 1.5 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4, 57 дугаар зүйлийн 57.2, Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1, 3.1.6 дахь заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд олгож байх;

**3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 21 мэдээллийн хугацаа хоцроож, Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх хэсэгт 29.6 сая төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээг мэдээлэхээс 24.5 сая төгрөгийн зарлагыг мэдээлж, 4.7 сая төгрөгийн зарлагыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх хэсэгт таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг тухай бүр мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	2	16.4			1	0.4	1	16.0		
2	Эрүүл мэндийн төв	5	65.9	1	41.6	1	20.8			3	3.5
3	Ерөнхий боловсролын сургууль	3	61.8	1	59.5	1	0.4			1	1.9
4	Төвлөрүүлэн захирагч	4	12.8	1	0.6					3	12.2
<b>Дүн</b>		<b>14</b>	<b>156.9</b>	<b>3</b>	<b>101.7</b>	<b>3</b>	<b>21.6</b>	<b>1</b>	<b>16.0</b>	<b>7</b>	<b>17.6</b>